



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 4/07

Улаанбаатар хот

Цагаан сарын баярын өдрүүдэд эмнэлгийн
тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг
ханган ажиллуулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/36 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1а/1026 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд ажиллах жижүүр эмч болон хариуцлагатай жижүүр нар сонор сэрэмжтэй, нэн хариуцлагатай ажиллах, зөрчил гарсан үед хугацаа харгалзахгүй ЭМЯ-ны хариуцлагатай жижүүрийн **11-323002** дугаарт утсанд мэдээлж танилцуулахыг үүрэг болгосугай.

2. Баярын өдрүүдэд тус төвийн Удирдлагын зөвлөлийн томилгоот гишүүд, Поликлиник болон Клиникийн тасгийн эрхлэгч болон энэхүү тушаалын хавсралтад заагдсан албан хаагч утсаа байнга нээлтэй, цэнэгтэй байлгаж, дуудсан тохиолдолд шуурхай ирж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Цагаан сарын баярын өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлийг нэгдүгээр хавсралтаар, хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчид болон жижүүр эмч нар, яаралтай үед дуудагдаж ажиллах эмнэлгийн мэргэжилтний хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Баярмаа), Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Б.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ

1525010081

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Захирлын
2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн
...4/07... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



1. Эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, нэгжийн ор, хүний зохицуулалтыг хийж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүн, хүчил төрөгчийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;
2. Цагаан сарын баярын бүх нийтийн амралтын өдрүүдэд иргэдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх 24 цагийн үйл ажиллагаатай утасны дугаар болон мэдээлэл өгөх эмнэлгийн мэргэжилтний нэр, зохицуулалтыг хийх
3. Өдөр тутам эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдах шаардлагатай иргэдийн эмчилгээг тасалдуулахгүй байхад чиглэсэн зохион байгуулалтыг хийх
4. Шаардлагатай тохиолдолд цахимаар зөвлөгөө авах, лавлагаа шатлалын байгууллагаас эмч дуудах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эмчилгээний хожимдол үүсгэхгүй байхад анхаарах, эргэх холбоотой ажиллах
5. Орон нутгийн байгууллагаас хандсан дуудлагын тохиолдол бүрд эмнэлзүйн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөөг шуурхай өгөх
6. Яаралтай тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үйлчлэх, үйлчлүүлэгчийг бусад эрүүл мэндийн байгууллагад хандуулж буцаахгүй оношилгоо, эмчилгээний асуудлыг нь шийдвэрлэх;
7. Түргэн тусламжийн дуудлагад шуурхай хариу арга хэмжээг авах;
8. Эмнэлгийн удирдлагын багаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавих, хуваарь, үүрэг чиглэлийг тодорхой болгож, зохион байгуулалттай ажиллах;
9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй ажиллагааны стандарт, дүрэм, журам, удирдамж, зааврыг хэрэгжилтэд онцгой анхаарах
10. Байгууллагын ажилтан албан хаагчдад ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй, сахилга хариуцлага алдахгүй, ёс зүйн зөрчил гаргахгүй, ажлын байраа орхиж явахгүй байхыг онцгой анхааруулж, хяналт тавих;
11. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын баг гар утсаа нээлттэй байлгаж, шуурхай холбогдох нөхцөл байдлыг бүрдүүлэх;
12. Эрүүл мэндийн байгууллагууд халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын тандалтыг идэвхжүүлж, мэдээг өдөр бүр гарган Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 89016199 дугаарт 08:00-22:00 цагийн хооронд мэдээлэх, халдварын сэргийлэлт хяналтын дэглэмийг баримталж, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;
13. Хүлээн авах, яаралтай тусламжийн хаягжилт, гэрэлтүүлгийн бүрэн бүтэн

байдлыг хангах;

14. Эмнэлэг хооронд үйлчлүүлэгч шилжүүлэхдээ зохих журмын дагуу эрүүл мэндийн байгууллагууд урьдчилан мэдээлэл солилцон бэлтгэл хангаж, тээвэрлэлтийн үед үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, тасралтгүй хяналт тавьж, эмчээс эмчид шилжүүлж, гардан хүлээлгэж өгөх;
15. Алсын болон ойрын түргэн тусламжийн дуудлагад явах автомашины техник аюулгүй байдал, шатахуун, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн мэргэжилтний дулаан хувцас, хэрэгслээр хангах;
16. Эмнэлгийн барилга, байгууламжийн ус, дулааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг шалгаж цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах;

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Захирлын
2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн
4/67 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Баярын өдрүүдэд ажиллах албан хаагчдын нэрс

№	Нэрс	Тасаг Албан тушаал	2025.03.01	2025.03.02	2025.03.03	2025.03.04	2025.03.05	Холбоо барих утас
1	Ж.Өүлэндарь	Захиргаа Хүний нөөцийн албаны дарга	Хяналт тавих удирдлага					89001909
2	А.Болормаа	Захиргаа Арга зүйч	Хариуцлагатай жижүүр эмч					85754810
3	Г.Наран-Од	Захиргаа Аюулгүй байдал, эрсдэлийн менежер	Жижүүр эмч					99765135
4	Ц.Амарзаяа	Захиргаа Статистикч		Хяналт тавих удирдлага				99760295
5	Н.Золбаяр	Хүүхдийн тасаг Их эмч		Хариуцлагатай жижүүр эмч				91060163
6	Д.Лхагвасүрэн	Поликлиник Их эмч		Жижүүр эмч				95235139
7	Т.Баярмаа	Захиргаа Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал			Хяналт тавих удирдлага			99061671
8	Б.Номин	Поликлиник Их эмч			Хариуцлагатай жижүүр эмч			99170840
9	М.Жамбалсүрэн	Поликлиник Их эмч			Жижүүр эмч			88025899
10	Б.Батцэцэг	Захиргаа Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал				Хяналт тавих удирдлага		99042132
11	Б.Баярмаа	1-р тасаг Эрхлэгч, их эмч				Хариуцлагатай жижүүр эмч		88182005
12	У.Саруул	Захиргаа Чанарын менежер				Жижүүр эмч		99802808

39	Р.Энхчимэг	Жор баригч						99886703
40	Д.Мөнхтулга	Аж ахуйн тасаг Жижүүр	24			24		95593189
41	Б.Батцоож			24			24	89228923
42	Б.Чинзориг				24			88150122
43	Д.Батхишиг	Цахилгаанчин	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	99894092
44	А.Буянцогт	Жолооч	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах				88649798
45	Б.Пүрэвбаяр	Жолооч			Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	Дуудагдаж ажиллах	86644220

-оОо-